

МОНГОЛ УЛСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ГОЛ УЛСУУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Б.Нандин-Эрдэнэ

***Хураангуй:** Сүүлийн үед Монголд оруулах гадаадын хөрөнгө оруулалтын урсгал эрдэс баялгийн олборлолт, ашиглалт эрчимжсэнтэй холбоотой байна. Ялангуяа Оюутолгойн ордыг ашиглахтай холбогдон машин механизм, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт огцом нэмэгдсэн учраас 2011 онд өмнөх онтой харьцуулахад гадаадын шууд хөрөнгө оруулалт 386%-иар өссөн. Монголын Татварын ерөнхий газрын материалаас үзэхэд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд сүүлийн зургаан жилийн хугацаанд 5 их наяд 408 тэрбум төгрөгийн татвар тушааж, 180 мянган ажлын байрыг шинээр бий болгожээ.*

***Түлхүүр үг:** гадаадын хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулагч улс, хөрөнгө оруулах салбар, хөрөнгө оруулалтын эзлэх жин, гуравдагч хөршийн бодлого*

Монгол Улсад хөрөнгө оруулж буй улсуудыг хөрөнгө оруулж буй хувиар үзвэл БНХАУ 38%, Хонг Конг 13%, Америк 13%, Сингапур 3%, Австрали 3% байна. Хөрөнгө оруулагч улсуудаас БНХАУ, Сингапур, Япон, АНУ-ын гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн бол бусад орнуудаас оруулсан гадаадын хөрөнгө оруулалт буурсан үзүүлэлттэй (Монголбанк, 2014) байна. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалтын орох урсгалд жинтэй хувь нэмэр эзэлдэг “БНХАУ, Хонг Конгоос хийгдсэн хөрөнгө оруулалт харгалзан 84%, 93%-аар буурчээ” гэж Монголбанкны гадаад секторын тоймд тайлбарлажээ. 2009 оныг хүртэл Хятад улс хамгийн их хөрөнгө оруулагч улс байсан бол 2010 онд Английн Виржини Арал, 2011 оноос хойш Нидерланд, Люксембург улсаас орж ирэх хөрөнгө оруулалтын хэмжээ давамгайлж байв.

PAX MONGOLICA

2016 оны 3-р сарын байдлаар Австралиас манай улсад оруулсан хөрөнгө оруулалт 2015 оны 3 дугаар улиралд –52.9 сая ам.доллар буюу хөрөнгө оруулалтаа буцаан татсан үзүүлэлттэй байсан бол 2016 оны эхний 9 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 65.0 сая ам.доллараар өсч 12.1 сая ам.долларт, БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 2015 онд 1.8 сая ам.доллар байсан бол 2016 оны 3 дугаар улиралд 47.7 сая ам.доллараар өсч -45.6 сая ам.долларт хүрсэн бол Голланд улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 39.9 сая ам.доллараар буурч –36.3 сая ам.долларт, Сингапур улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 20.4 сая ам.доллараар буурч –24.4 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

Хүснэгт 1 . Хөрөнгө оруулагч гол улсуудын эзлэх жин (бүртгэгдсэн, 2009-2016)

Улс	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2011-2016 М/дүн (Мян.\$)
	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	
АНУ	11%	2%	6%	2%	2%	3%	3%	4%	559,164.00
БНСУ	2%	1%	2%	1%	0%	1%	1%	1%	127,314.73
БНХАУ	6%	1%	8%	5%	4%	6%	6%	12%	1,499,579.85
Виржиниа арал	0%	51%	0%	0%	0%	0%	0%	0%	-
Их Британи	8%	14%	8%	7%	8%	8%	7%	8%	1,010,543.81
Канад	43%	0%	5%	1%	1%	2%	2%	3%	423,667.24
Люксембург	1%	3%	0%	1%	2%	2%	2%	3%	350,923.96
Нидерланд	1%	9%	14%	57%	53%	52%	50%	34%	4,405,506.57
ОХУ	8%	1%	2%	1%	1%	1%	1%	0%	42,415.68
Сингапур	0%	8%	2%	11%	8%	8%	8%	10%	1,322,433.65
Хонг конг	4%	1%	41%	4%	4%	8%	8%	11%	1,433,203.09
Япон	9%	2%	6%	1%	1%	1%	2%	4%	464,782.61
Бусад	8%	6%	6%	10%	17%	8%	8%	10%	1,340,866.62
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	12,980,401.8

Эх сурвалж: Монголбанк, Гадаад секторын тойм

Монголд хөрөнгө оруулж буй улсуудын эзлэх жинг авч үзвэл хөрш орнуудын хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр байна. Манай улсын эдийн засгийн нөхцөл байдал, гадаадын хөрөнгө оруулалтад хөрш орнуудын эзлэх байр суурь өндөр билээ. Монгол Улс болон хөрш орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны талаар товч авч үзье.

БНХАУ бол Монголд хөрөнгө оруулагч тэргүүлэх улсуудын нэг

*Монгол Улсад хөрөнгө оруулагч гол улсуудын хөрөнгө оруулалтын
өнөөгийн төлөв байдал*

бөгөөд (хүснэгт 4-д) үзүүлсэнчлэн 1990-2016 оны хооронд Монголд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 4.5 тэрбум доллар буюу гадаадын шууд хөрөнгө оруулалтын 35%-ийг эзэлсэн байна.

Монгол Улс, БНХАУ-тай 1949 онд дипломат харилцаа тогтоосон ба хоёр улсын харилцаа 2003 оны “найрсаг хөршийн түншлэлийн харилцаа”-наас 2011 оны “стратегийн түншлэлийн харилцаа”-тай болж хөгжжээ. Өнөөгийн байдлаар хоёр улсын хооронд хамтын ажиллагааны жар гаруй гэрээ хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж байна (И Жэ Ён, 2014, хууд. 111).

Монголд оруулах БНХАУ-ын шууд хөрөнгө оруулалт жил бүр өссөн ба 2010 онд хөрөнгө оруулалт өмнөх оныхоос буурсан бол 2011 онд өмнөх оноос 476.7%-иар нэмэгджээ. 2010 онд тус улс нь арван хоёр салбарт хөрөнгө оруулсан ч Монголын уул уурхайд оруулах хөрөнгө оруулалт нь дэлхийн эдийн засгийн хямралын улмаас өмнөх онтой харьцуулахад дөрөв дахин буурч, хөрөнгө оруулалтын нийт хэмжээ ч багасчээ.

БНХАУ нь Монголын эрдэс баялгийг ашиглахад хамгийн их хөрөнгө оруулсан улс бөгөөд эрдэс баялаг, нефтийн хайгуул, ашиглалтын салбарт нийт 2.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь энэ салбарт оруулсан гадаадын нийт хөрөнгө оруулалтын 71.9%-ийг эзэлж байна. Уул уурхайн салбарын дараа худалдаа, нийтийн хоолны салбарт 626.6 сая ам.долларын хөрөнгө оруулсан нь нийт хөрөнгө оруулалтын 18%-ийг эзэлжээ. Үүний дараа барилга, барилгын материал, МАА-н боловсруулах үйлдвэр, хөнгөн үйлдвэрийн салбарууд орж байна.

Монголын уул уурхайн салбарт хөрөнгө оруулсан БНХАУ-ын гол компани гэвэл Монголын Засгийн газартай нефтийн салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан China Golden Sea Petroleum (2007.03.07), Zhong Hen Yu Tang (2009.05.20) болно. Монголын Засгийн газартай Тогтвортой байдлын гэрээ байгуулсан Tsairt Mineral, Chin hua Mak Naryn Sukhait, Mongolia mid-Asia International зэрэг компаниуд бий. БНХАУ нь Монголд голдуу нефть, алт, цайр, нүүрс, төмөр, полиметал, хээрийн жонш, тугалга, фосфорит, барилгын материалын хайгуул, ашиглалтын ажил хийж байна.

Монголд хөрөнгө оруулсан тус улсын компанийг хамтын

ажиллагааны хэлбэрээр авч үзвэл, БНХАУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай компани 72,2%-ийг эзэлж байна. Дараа нь Монгол БНХАУ-ын хамтарсан компани 23,9%-ийг, үлдсэн хувийг БНХАУ, Өвөр Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ), Хонг Конг болон бусад улсуудтай хамтарсан компани эзэлж байна (И Жэ Ён, 2014, хуудсд. 112-115).

Монгол Улсад оруулах гадаадын шууд хөрөнгө оруулалтад БНХАУ-ын хөрөнгө оруулалт хамгийн их байгаа нь дараах шалтгаантай гэж судлаач И Жэ Ён үзсэн байдаг. Үүнд:

1. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, боловсруулах үйлдвэрийн хөгжлийг дагаад байгалийн баялгийн хэрэгцээ тогтмол өсч байгаа ба байгалийн баялгийг ашиглах дэлхийн өрсөлдөөнд БНХАУ гол өрсөлдөгч орнуудын нэг болоод байна. Монгол Улс байгалийн баялаг ихтэй улс тул байгалийн баялгийг нь ашиглаж болох чухал бүс нутаг болон тодорч байна.
2. БНХАУ, Монгол хоёр улсын газар зүйн байрлал нь БНХАУ-ын Монголд оруулах хөрөнгө оруулалтаа ихэсгэх чухал хүчин зүйл болдог.

БНХАУ аль болох Монголын газрын баялгийг импортлох сонирхолтой бол Монгол нь ямар нэг хэмжээгээр боловсруулалт хийсний дараа экспортлох сонирхолтой. Өнөөгийн байдлаар Монгол нь экспортлох гол бараа болох эрдэс баялаг, уул уурхайн бүтээгдэхүүнийг бараг 100% БНХАУ-д экспортлож байна (И Жэ Ён, 2014, хуудсд. 112-115).

Монгол Улс Оросын Холбооны Улс (ОХУ)-тай 1921 онд албан ёсоор дипломат харилцаа тогтоож, “Сайн хөршийн найрсаг харилцааны тухай Монгол Зөвлөлтийн гэрээ” байгуулснаар харилцаа хөгжжээ. 1993 онд “Орос, Монголын найрамдал, хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулж, 2006 онд хоёр улсын харилцааг “стратегийн түншийн харилцаа” хэмээн тодорхойлсноос хойш эдийн засгийн хамтын ажиллагаа аажмаар сэргэж байна.

2011 онд хөрөнгө оруулалт өмнөх оныхоос 2,4%-иар өссөн нь уул уурхайд 44.4 сая ам.доллар, тээвэрт 5.4 сая ам.доллар, худалдаа, хоол үйлчилгээний салбарт 6.4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. ОХУ-ын Монголд оруулах хөрөнгө оруулалтын 64,9%

*Монгол Улсад хөрөнгө оруулагч гол улсуудын хөрөнгө оруулалтын
өнөөгийн төлөв байдал*

нь уул уурхай, нефтийн салбарт төвлөрч байгаа бөгөөд түүний удаад худалдаа, хоол үйлчилгээний салбарт 12,6%-ийг эзэлж байна. Тээврийн салбар 6%, барилгын салбар 3,2%, санхүүгийн салбар 2,9%, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2,9% орж байна.

Монголын зах зээлд нэвтэрч хөрөнгө оруулалт хийсэн ОХУ-ын компаний тоо төдийлөн их бус хэдий ч Монголын гол стратегийн аж ахуйн нэгж болох “Улаанбаатар төмөр зам”-ын хувьцааны 50%, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн хувьцааны 49%-ийг эзэмшиж байна. Сүүлийн үед ОХУ нь Монголын уул уурхайн салбар, ялангуяа алт, молибден, холимог металл, ураны ордууд болон Тавантолгойн ордын ашиглалтанд ихэд анхаарал хандуулах болсон. Мөн худалдаа, банкны салбарт хөрөнгө оруулалт хийх сонирхол нь ихэссэн. Жишээ нь, 2001 оны 5-р сард “Чингис хаан Банк”-ыг 100%-ийн хөрөнгө оруулалттайгаар байгуулсан байна (И Жэ Ён, 2014, хуудсд. 117-119). Хөрш улсуудын гадаадын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа манай улсын хувьд ихээхэн ач холбогдолтой, эерэг нөлөөтэй. Монгол Улс хэдий хоёр том гүрний дунд оршин найрсаг харилцаатай байдаг ч гуравдагч хөршийн бодлогыг тууштай баримталдаг.

Монгол Улс гуравдагч хөршийн тоонд АНУ, Япон зэрэг улсыг онцгойлон авч үздэг. АНУ-ын хувьд 2010 оноос хөрөнгө оруулалт эрчимжин 2011 онд шууд хөрөнгө оруулалт 127,240,000 долларт хүрч, өмнөх оныхоос 814,7%-аар өсчээ. Уул уурхай, нефтийн салбарт 45,9%, худалдаа, нийтийн хоолын салбарт 23,6%, санхүүгийн салбарт 15,7%-ийн хөрөнгө оруулалт хийжээ.

Японы хөрөнгө оруулалт нь Монголын худалдаа, нийтийн хоолны салбарт төвлөрсөн бөгөөд энэ нь нийт хөрөнгө оруулалтын 48,5%, хөнгөн үйлдвэрийн салбар 17,6%, санхүүгийн салбар 7,3%, барилгын салбар 7,2%-ийг эзэлж байна. Японы Монголд оруулж буй хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулагч гол улсуудынхаас ялгаатай, өөрөөр хэлбэл худалдаа, үйлдвэр, үйлчилгээний салбарт голлон хийгдэж буйгаараа онцлогтой юм (И Жэ Ён, 2014, хуудсд. 121-131).

Европын орнуудаас Нидерланд улс хөрөнгө оруулалтын хэмжээгээр тэргүүлж байна. Тус улсын хөрөнгө оруулалтын хэмжээ 2009 оноос эрчимтэй өсөн 2012 оноос 50-аас дээш хувийн эрчимтэй өсөлттэй байна.

Нидерланд болон Люксембург хөрөнгө оруулалтаараа хамгийн их байгаа нь эдгээр улсууд Монгол Улстай “Давхар татварын гэрээ” байгуулсантай шууд холбоотой. Монгол нь зах зээлийн эдийн засгийн системд шилжсэнийхээ дараа гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд татвараас чөлөөлөх, хөнгөлөх зэргээр хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлжээ. Энэ явцад хөрөнгө оруулалтын хууль эрхзүйн орчинг нилээд уян хатан болгож олон улсын байгууллагууд болон дэлхийн олон орнуудтай гэрээ хэлэлцээр байгуулсан байна. Яг эндээс хуулийн цоорхой үүссэн бөгөөд Монголын зах зээлд нэвтэрсэн зарим хөрөнгө оруулагчид, ялангуяа уул уурхайн толгой компаниуд уг сул талыг ашиглаж ирсэн байна. Эдгээр охин компаниуд нь Нидерланд, Люксембургийн бүртгэлтэй байдаг.

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу оршин суугч бус, татвар төлөгчийн хүүгийн орлогоос 20%-ийг нь татварт суутган авдаг. Гэтэл Бельги, Франц, Люксембург, Нидерланд болон Швейцарь улсуудтай байгуулсан давхар татварын гэрээгээр банк буюу санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн орлогод, Кувейт болон Арабын Нэгдсэн Амират Улсуудтай байгуулсан гэрээгээр бүх төрлийн хүүгийн орлогод Монгол Улсад татвар ногдуулахгүй заалттай байна.

“Давхар татварын гэрээ”-ний энэ мэт сул талыг ашиглаж, гадаадын хөрөнгө оруулагч компаниуд Нидерланд, Люксембургт толгой компаниа бүртгүүлэх замаар татвараас зайлсхийж иржээ. Тийм учраас 2012 оны 11-р сард Улсын Их Хурлаас Монгол Улсын Арабын Эмират, Нидерланд, Люксембург, Кувейт улсуудтай байгуулсан “Орлого, хөрөнгийн татварт давхар татвар ногдуулахыг хариглох, татвараас зайлсхийх явдлаас сэргийлэх гэрээ”-г хүчингүй болгожээ. Монголын хамгийн том үүрэн телефоны компани болох Японы хөрөнгө оруулалттай Мобиком, Бороогоулд компани хүртэл Нидерландынх хэмээн бүртгүүлж, татвараас зайлсхийж иржээ (И Жэ Ён, 2014, хуудасд. 130-132).

*Монгол Улсад хөрөнгө оруулагч гол улсуудын хөрөнгө оруулалтын
өнөөгийн төлөв байдал*

Хүснэгт 2. Монгол Улсаас бусад улстай байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”-ийн жагсаалт (2014 он)

Улс	Огноо	Улс	Огноо
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	1993.01.01	Бельгийн Вант Улс	1999.01.01
Бүгд Найрамдах Солонгос Улс	1993.01.01	Бүгд Найрамдах Казахстан Улс	2000.01.01
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	1997.01.01	Бүгд Найрамдах Киргиз Улс	2000.01.01
Бүгд Найрамдах Энэтхэг Улс	1997.01.01	Бүгд Найрамдах Польш Улс	2002.01.01
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	1997.01.01	Люксембургийн Вант Улс ²	2002.01.01
Бүгд Найрамдах Турк Улс	1997.01.01	Бүгд Найрамдах Болгар Улс	2002.01.01
Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	1997.01.01	Швейцарын Холбооны Улс	2002.01.01
Бүгд Найрамдах Унгар Улс	1997.01.01	Украин Улс	2003.01.01
Малайз Улс	1997.01.01	Канад Улс	2003.01.01
Оросын Холбооны Улс	1998.01.01	Арабын Нэгдсэн Эмират Улс ³	2003.01.01
Бүгд Найрамдах Индонези Улс	1998.01.01	Бүгд Найрамдах Сингапур Улс	2005.01.01
Кувейт Улс ¹	1998.01.01	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс	2005.01.01
Бүгд Найрамдах Франц Улс	1999.01.01	Бүгд Найрамдах Австри Улс	2005.01.01
Бүгд Найрамдах Чех Улс	1999.01.01	Нидерландын Вант Улс ⁴	2005.10.31

Эх сурвалж: Эх сурвалж: Монголбанк, Судалгааны ажил, Татварын Ерөнхий Газар

Тэмдэглэгээ:

1. “Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Кувейт Улсын хоорондын хэлэлцээр”-ийн үйлчлэл 2015 оны 4-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр бус болно.
2. “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн үйлчлэл 2014 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр бус болно.
3. “Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Арабын Нэгдсэн Эмират Улсын хоорондын хэлэлцээр”-ийн үйлчлэл 2015 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр бус

болно.

4. “Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Нидерландын Вант Улсын хоорондын хэлэлцээр”-ийн үйлчлэл 2014 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр бус болно (Мөнхцэцэг.Д, 2015, р. 664).

Хүснэгт 3. Гадаадын хувь, оролцоотой томоохон 20 компани

Д/Д	Компанийн нэр	Анх хөрөнгө оруулсан хугацаа	Нийт Хөрөнгө (Сая \$)	Гадаад Хувь эзэмшил (%)	Салбар	Оролцоотой талууд
1	Оюу Толгой	2000	108.5	66	Уул уурхай	Нидерланд, Виржини Арлууд
2	Чингис Хаан Банк	2006	32.6	100	Банк	Виржини Арал
3	Болд Төмөр Ерөө Гол	2004	18.9	100	Уул уурхай	Виржини Арал
4	Гоёо	2006	18	100	Ноос, ноолуур	Сингапур
5	Reabody	2007	61	100	Уул уурхай	Нидерланд
6	ХААН Банк	2004	20.6	66	Банк	Япон, Хятад, ХонгКонг, АНУ
7	Эм Си Эс Азия	2005	23	55	Ус, ундаа	Сингапур, Монгол
8	Арева Монгол	2005	12.5	100	Уул уурхай	Франц
9	Мобиком	1995	10.7	79	Харилцаа, холбоо	Нидерланд, Монгол
10	Улаанбаатар ИС	1995	6.7	98	Боловсрол	БНСУ, АНУ, Монгол
11	Вагнер Ази	1996	6.4	100	Машин, т/т	АНУ
12	Схай Ресорт	2008	20.9	26	Аялал, жуулчлал	Виржини Арал
13	Централ Азиан Цемент	2003	5.5	98	Барилга	Бельги, Нидерланд, Сингапур
14	Tethys Майнинг	2004	26.9	100	Уул уурхай	Швейцарь
15	Монголросцветмет	2007	10.5	49	Уул уурхай	Монгол, ОХУ
16	Худалдаа Хөгжлийн Банк	2002	3.8	80	Банк	Люксембург, Монгол, АНУ
17	Чинхуа МАК	2002	3.6	50	Уул уурхай	Хятад, Монгол
18	ҮХО Банк	2006	3.2	44	Банк	Кайман Арал, Хятад, ХонгКонг
19	Сүнжин Групп	2006	2.3	100	Аялал, жуулчлал	БНСУ
20	Сөүл Групп	1996	1.1	95	Үл хөдлөх	БНСУ, Монгол

Эх сурвалж: Монголбанк, Судалгааны ажил

Гадаадын хувь, оролцоотой томоохон 20 компанийн долоо нь уул уурхайн салбарт, дөрөв нь банкны салбарт үйл ажиллагаа явуулдаг болох нь Хүснэгт 5-аас харагдаж байна. Түүнчлэн гадаадын томоохон хувь, оролцоотой компаниуд нь татварын диваажин гэгддэг Нидерланд, Английн Виржинийн Арлууд, Люксембург улсуудад бүртгэлтэй байна (Мөнхцэцэг.Д, 2015, хуудсд. 661-662).

НОМ ЗҮЙ:

5. И Жэ Ён, Жэ Сон Хүнь, Ким Хун Жинь, Мөнхнасан.Г, Монгол улсын хөрөнгө оруулалтын орчин, БНСУ-ын аж ахуйн байгууллагууд Монголын зах зээлд өргөнөөр нэвтрэх нь, Улаанбаатар, 2014 он
6. Монголбанк, Гадаад секторын тойм. 2014 оны 3-р улирлын гүйцэтгэл.
7. Монголбанк, Судалгааны ажил, Татварын Ерөнхий Газар
8. Мөнхцэцэг.Д, Гантөмөр.П, Гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах зохистой бодлого, Улаанбаатар, 2015 он